



Улаанбаатар хот

“Шугаман эргүүл, Цагийн менежмент”
хяналт шалгалт, нөлөөллийн ажилд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг түс түс үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагдаагийн Ерөнхий газрын Тэргүүн дэд даргын баталсан “Шугаман эргүүл, Цагийн менежмент” хяналт шалгалт, нөлөөллийн ажлын хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай хатуу хучилттай автозам дагуу 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ны өдрүүдэд 24 цагаар хөдөлгөөнт эргүүлийн хяналт шалгалтыг зохион байгуулсугай.

2. “Шугаман эргүүл, Цагийн менежмент” хяналт шалгалт, нөлөөллийн ажлын хүрээнд улсын чанартай А0101 автозамын 57-92 дахь километр хүртэл хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэх албаны тээврийн хэрэгслийг нэгдүгээр, шаардагдах шатахууны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Хяналт шалгалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахад зарцуулагдах 3,072,000 (гурван сая далан хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, нөлөөллийн ажлын тайланг арга хэмжээ зохион байгуулагдсанаас хойш ажлын 5 өдөрт багтаан эргэн танилцуулж ажиллахыг Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн
А.М. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“ШУГАМАН ЭРГҮҮЛ, ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ”
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

д/д	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар
1	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	Duster	13-26 УАМ
2		Kia rio	23-61 УАТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 09-ны өдрийн
81/87 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“ШУГАМАН ЭРГҮҮЛ, ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ” ХЯНАЛТ
ШАЛГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ЗАРЦУУЛАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Шатахуун	Литр	1200	2560	3,072,000
	Нийт				3,072,000